

«Шинэ Гэрээ»-нд гардаг хоёр “там”



Ариун Библийн аппын хайлт зөв ажилласан бол тус орчуулганд нь “там” гэдэг үг 13 удаа гардаг бөгөөд бүгд «Шинэ Гэрээ»-нд бий. Цаана нь буй грек хэлний хоёр янзын үгийг адилхан “там” гэж орчуулсан байдаг. Үүнд: “гехенна” (12 удаа) бас “тартароо-у” (1 удаа).

“Там” гэж ойлгогддог Библийн эх үгс

-Еврей (ХГ)

*Шеол/Sheol -65х

(АБ: Үхэгсдийн орон)

-Грек (ШГ)

*Хадес/Hades – 11х

(АБ: Үхэгсдийн орон)

*Тартарус/Tartarus – 1х

*Гехенна/Gehenna -12х

Эхлээд ганц удаа гардаг “тартароо-у” ([ταρταρώ](#), [tartaroō](#), G5020) хэмээх үйл үгийг авч үзье. Энэ үгийн гарал үүсэл нь эртний грекчүүдийн шашны домог билээ. Тэр домгийн дагуу Тартарус нь муу үйлс хийсэн Кронос мэтийн титан бурхдын шийтгэгдэж буй газар. Алдартай «Илионы дуулал»-ыг бичсэн грек яруу найрагч Хомерын дагуу “хөрст дэлхийгээс дээшээ тэнгэрийн улс хол байдгийн адил Хадесээс (Үхэгсдийн орноос) доошоо Тартарус гүн дор байдаг”. Бурхдын хааны үгэнд ороогүй бурхад Кроностой хамт түнэр харанхуй, уй гашуутай тэр газарт шийтгүүлдэг хэмээн Хомер бичив.¹



“Тартароо-у” гэдэг нь энэ ойлголтыг ашиглаад “Тартарус уруу хаях” гэсэн утгатай үйл үг. Энэ үйл

1 Хомер. (МЭӨ 750). *Илионы дуулал*, 8-р боть. Англи орчуулга нь: <http://www.theoi.com/Text/HomerIliad8.html>



«Шинэ Гэрээ»-нд гардаг хоёр “там” □ 2

үгийг өөр хаанаас ч олоогүй болохоор Пэтрийн зохиосон зүйрлэлт үг байх бололтой. Тухайлбал: **“Хэрэв Бурхан нүгэл үйлдсэн тэнгэр элч нарыг хэлтрүүлэлгүй, харин тэднийг тамд хаяад [тартароо-у], харанхуйн гинжинд тушааж, шийтгэлийн төлөө хадгалсан бол...”** (2 Петр 2:4). Энэ ишлэлд гардаг “там” тэгвэл гэм хийсэн *ер бусын элч нарт* хамаатай. Гяндан мэт энэ газарт тэд *хадгалаастай* бөгөөд шийтгэлээ хүлээж буй мэт.

Ойлгоход хэцүү энэ ишлэлээс ямар ч байсан нэг зүйл их тодорхой байна: Тартарусын “там”-д ер бусын элч нар орсон ч хүн орох тухай нэг ч үг алга.

Тэгвэл Есүсийн сэрэмжлүүлж байсан “там” юуг хэлдэг вэ?

“Есүс тамын тухай их ярьсан” гэж баримталдаг хүмүүс Түүнийг энэ дэлхий дээр байхдаа монголоор эсвэл англиар ярьдаггүй байсныг санах нь зүйтэй. Юу гэвэл, Есүс “там” хэмээх монгол үгийг (мөн “hell” хэмээх англи үгийг) хэзээ ч хэрэглэж байгаагүй. Есүс еврей хэлтэй ойр болох арамай хэлээр ярьдаг бөгөөд еврей сэтгэлгээтэй байсан. «Шинэ Гэрээ» нь грекээр бичигдсэн ч гэсэн мөн адил еврей сэтгэлгээ нэвт шингэсэн ном.

Монгол хэл рүү орчуулсан Есүсийн “тамын тухай үг” нь грекээр нэг бол “Хадес” (G86) нэг бол “Гехенна”-ийн тухай юм. Хадес тухай өмнөх



«Шинэ Гэрээ»-нд гардаг хоёр “гам” □ 3

нийтлэлдээ авч үзсэн бөгөөд одоо “гэхенна” ([γέεννα, geenna, G1067](#)) хэмээх үгийг авч үзнэ.

Есүс “гехенна”-гийн тухай 11 удаа ярьсан бөгөөд грекжүүлсэн энэ еврей үг “гэе хинном” (H1516+H2011) буюу “Хинномын хөндий” гэсэн утгатай газрын нэр юм. “Хинномын хөндий” өдий хүртэл Иерусалим хотын баруун өмнөд талд оршдог гуу жалга юм.



Өнөөдөр ч [Google-н газрын зургаар](#) олж болно. Газрын оноосон нэрийг томоор эхлэн бичдэг дүрмийн дагуу тус хөндийн нэрийг томоор бичих ёстой. Ариун Библид “Ром”, “Эфэс”, “Бетлехем”, “Вавилон” зэрэг газрын нэрийг галиглан тавьсан байхад “Гехенна” хэмээх газрын нэрийг л галиглаагүй, “Хинномын хөндий” гэсэн утгыг нь ч



орчуулаагүй, харин “там” гэсэн үгийг оронд нь тавьсан байна. “Бор” Библид теологичдийн “там”-ын тухай ойлголтыг шууд л тулгаж оруулан “мөнхийн зовлон” гэж тавьсан байна. “Гехенна” гэгч газрын нэрийг огт орчуулаагүй харин өөр ойлголтоор орлуулсан нь уламжилж ирсэн олон улсын Библийн орчуулгын орчуулгаас улбаатай юм.

Өнөөдөр зугаалгын парк болсон тэр нарийн хөндийд эрт үед Иерусалим хотын хогийг шатаадаг, тэнд байнга гал асдаг байсан учраас тэр хөндий тамыг билэгддэг гэж олон Библийн багш тайлбарладаг. Тийм учраас тус хөндийн нэрийг "там" гэж орчуулж болно гэж үзнэ. Үнэхээр тийм гэж үү? Тэнд хог шатаадаг байсны бодит археологийн юмуу эртний түүхийн баталгааг хайвал олдохгүй. 13-р зууны үед л Рабби Давид Кимхи (Rabbi David Kimhi) гэдэг иудей багш “Гехенна бол хог новш ба хүүрийг шидэн галд шатаадаг жигшмээр зэвүүн газар бөгөөд ийнхүү ёрын муу хүмүүсийн шийтгэлийн зүйрлэл болсон” гэж бичсэн. Ингээд тэр багш анх удаа энэ ойлголтыг гаргаж ирсэн. Гэвч эртний олон номд тэр хөндийд хог шатаадаг байсан талаар огт өгүүлээгүй, археологийн нотолгоо ч энэ талаар байхгүй гэдэг. Теологчдын Давид Кимхи





багшаас авсан санаа үнэн хэрэгтээ ямар ч бодит үндэслэлгүй бөгөөд МЭ 1200 оны үеэс үүссэн домог төдий юм. Гэтэл Библийг домгоор “орчуулж” болно гэж үү?

Тус хөндийн нэр «Хуучин Гэрээ»-нээс нэг бол “Хинномын хөндий” эсвэл бүтэн нэрээрээ “Геэ бен Хинном” (Gey ben Hinnom) буюу “Хинномын хүүгийн хөндий” гэснээр олддог. Энэ газар анх удаа тус хоёр нэрээрээ Иошуа 15:8-т дурдагдан, Иуда овгийн хойд талын хил хязгаарын шугамыг тэмдэглэдэг байжээ. АБ-д “бен” буюу “хүү” гэсэн үгийг орчуулалгүйгээр “Бен-хинномын хөндий” гэж тавьсан (СМО: “Хинноомын гуу” буюу “Бэн-Хинноомын гуу”). «Хуучин Гэрээ»-нд энэ нэр нийт 13 удаа дурдагддаг бөгөөд тус бүртээ бодит тэр хөндийг нэрлэдэг.

Тэгсэн ч гэсэн «Шинэ Гэрээ»-нд энэ газрын нэрийг “там” гэж “орчуулсан”. Үүнээс болоод «Хуучин Гэрээ»-нд буй энэ нэрийн жинхэнэ үндсэн гарал нь монгол уншигчдад мэдэгдэхгүй болтлоо балартсан байна. «Хуучин Гэрээ», «Шинэ Гэрээ» хоёрын хоорондох холбоо нь ийнхүү таслагдсан нь буруу ойлголтонд хүргэдэг бөгөөд энэ буруу ойлголт даанч маш их хор уршигтай аж.

«Хуучин Гэрээ»-г судлахад Хинномын хөндийд хог шатаадаг байсан домгийн тухай юу ч олдохгүй нь



лавтай. Гэвч тэнд аймшигтай өөр зориулалтын гал дүрэлздэг байсан тухай өгүүлсэн бий. Яг тэр хөндийд МЭӨ 8-р зуунд Иуда улсын 12 дахь хаан болох Ахаз Канаанчуудын шүтдэг байсан бурхан Молээхыг шүтэж **“израилчуудын өмнөөс ИАВЭгийн хөөн зайлуулсан үндэстнүүдийн жигшүүрт зан үйлийг дагаж, Бен-хинномын гуунд утлага уугиулан, хөвгүүдээ галаар өргөн шатаажээ”** (2 Шастир 28:3, СМО).²

Хүүхдээр тахил тахих гэдэг Ертөнцийн Эзэний Мосед өгсөн Хуулийн эсрэг үйлдэл. Үүнд: **“Үр хүүхдээ Молехт өргөл болгон бүү тахь. Чи Бурханыхаа нэрийг бүү гутаа. Би бол ИАВЭ”** (Левит 18:21, СМО).

Гэвч Ахазын ач Манассе Хаан мөн адил **“Бен-хинномын гуунд хөврүүдээ галд шатааж, зөн совин тайлах, мэргэ төлөг тавих, хараал жатга хийх явдлаар хөөцөлдөн, сүнс дуудагчид хийгээд үзмэрчидтай сүлбэлдэж байлаа.**



2 Зургын тайлбар: Дотроо хөндий бурханы хөшөөний ар талд буй нүхэнд тахилчид гал асаадаг байв. Зэс юмуу гуулин хийцтэй бурханыг халахаар хүүхдийг гарт нь тавьдаг. Хөөрхий амьтаны хашгирахыг хүмүүст сонсгохгүйн тулд бөмбөр дэлсдэг, бүрээ үлээдэг байв. Энэ мэдээлэл Библид байхгүй, түүхийн баримт бичгээс гаралтай.



Түүнчлэн ИАВЭгийн мэлмийн өмнө бузар муу явдлыг дэвэргэж, уур хилэнг нь бадраав” (2 Шастир 33:6, СМО).

Бен-хинномын хөндийд болсон энэ аймшигтай гэмт хэргийн эсрэг Бүтээгч Эзэний уур хилэн дүрэлзсэн гэдгийг Иеремиа бүр гурван удаа сэрэмжлүүлдэг. Тухайлбал:

“Миний тушаагаагүй, ухаан санаанд ч минь ороогүй юмыг хийж, охид хөвгүүдээ шатаах гэж Бэн-Хинноомын гуунд Тоофэтын тахилгын овоонуудыг барьж босгосон.

Үзтүгэй! Тэгэхлээр Тоофэтод зайгүй болтол нь хүн оршуулах тул Тоофэт³, эсвэл Бэн-Хинноомын гуу гэхгүй, харин Аллагын гуу [АБ: “Хядлагын хөндий”] гэж нэрлэх цаг ирлээ. ИАВЭ Би тунхаглаж байна. Энэ хүмүүсийн хүүрээр газрын араатан, огторгуйн шувуудыг хооллох ба үргээж цочоох хэн ч үгүй байх болно...” зэрэг аймшигтай үг бичсэн (Иеремиа 7:31-33, СМО).

Ёрын муу энэ гэмийн төлөө Хинномын тэр хөндий ирээдүйд Иерусалим хотынхныг шийтгэх газар болохыг Иеремиа энд зөгнөсөн байна.

3 Тоофэт бол Бэн-Хинномын хөндийд босгосон мөргөлийн газрын төрлийн нэр. Хүүхдийг галаар тахиад үлдэгдлийг нь оршуулдаг байсан тийм газар мөн Карфаген зэрэг хотуудад байсан. Карфаген хотын тоофэтыг МЭӨ 730 оноос МЭӨ 146 онд ромчуудад эзлэгдтлээ байнга ашигладаг байсан бололтой. Карфагенийг анх Канаанаас ирсэн Финикчүүд байгуулжээ.



«Шинэ Гэрээ»-нд гардаг хоёр “гам” □ 8

Иеремиагийн үгийг лав сонссон Иуда улсын 16-р хаан Иосиа “хэнийг ч хүү, охиноо **Молээхт өргөл болгон галд шатаалгахгүйн тулд Бэн-Хинноомын гуунд байсан Тоофэтыг бузарлан сүйтгэв**” (Хаадын дэд 23:10, СОМ; Иеремиа 1:2).

Энэхүү ялзарсан шашны үйл ажиллагааг зогсоосон Иосиа Хаан Их Эзэний сайшаалыг хүртсэн. Дээрх ишлэлээс харахад ганцхан хаадууд биш, хэн ч хамаагүй тэр газарт өөрийн гэмгүй хүүхдээ харийн бурханд өргөл болгон шатаадаг байжээ.

Иеремиагийн дараах үг үүнийг бүр тодорхой харуулдаг:

“ИАВЭ ийнхүү айлдлаа. ”Ард олны ахмадууд хийгээд тахилчдын ахлагчдаас авч яваад,

ваарчныд очиж, шавар ваар худалдаж ав.

Тэгээд Харсийт гулдан хаалганы ойролцоох Бен-Хинноомын гуу руу очин, Миний чамд хэлэх үгийг тэнд тунхагла.

Чи «ИАВЭгийн үгийг сонсогтун! Иехудаагийн хаад аа, Йерусалимын оршин суугчид аа! Израилийн Бурхан, туг түмдийн

ИАВЭ ийнхүү айлдаж байна. ‘Үзтүгэй, Би энэ газарт гай гамшиг авчирна. Үүний тухай сонссон хүн бүрийн хоёр чих хангинана’ гэж хэл. Яагаад





гэвэл тэд Намайг умартан орхиж, энэ газарт харь юм шиг хандав. Тэгээд өөрсдөө ч, эцэг өвгөд нь ч, Иэхүдаагийн хаад ч мэддэггүй өөр бурхдад утлага уугиулан, энэ газрыг гэмгүй амь цусаар дүүргэлээ. Тэрчлэн хөвгүүдээ галд шатаан, Баалд шатаах тахил болгох гэж Баалын тахилгын овоонуудыг барьж байгуулсан.

Энэ нь Миний тушаагаагүй, хэлээгүй, бүр санаанд минь ч ороогүй зүйл юм.

Тиймээс, үзтүгэй! Энэ газрыг Тоофет эсвэл Бен-Хинноомын гуу гэхгүй, харин Аллагын гуу гэж нэрлэх цаг ирлээ. ИАВЭ Би тунхаглаж байна.” (Иеремиа 19:1-6, СМО).

Хинномын хөндий буюу Гехеннад гэмгүй хүүхдийг галд шатаах бодол Бүтээгч Эзэний санаанд ч ороогүй байсныг Тэр ахин дахин хэлсэн. Энэ гутамшигтай мөргөл Түүний уур хилэн бадрахад хүрсэн юм. Тийм байхад теологичид яг тэр хөндийг хүн төрөлхтөний дийлэнх хэсэг Бүтээгч Эзэнээр үүрд мөнхийн галаар тамлуулах там болгосон гэж бод доо!

Та юу гэж бодож байна? Өнөөх ёрын муу шашин шүтээд хүүхдээ галд шатаадаг байсан хүмүүсээс Ертөнцийн Эзэн долоон доор гэж үү? Хүүхдийг тахил болгон шатаах нь үнэхээрийн аймшигтай хэрэг байсан ч ядаж тэр хүүхдийн зовлон хором зуур байсан буй за. Гэтэл Их Эзэн Өөрийн хайрын бүтээл болох хүмүүсээ түр зуур ч биш, харин үеийн үед, мөнхийн мөнхөд,



үүрдийн үүрд дүрэлзэх галд шатаасаар байх болно гэдэгт олон хүн итгэдэг шүү дээ!

Харин ТА Мөнхийн Эзэнийг юу гэж үздэг вэ?

32-р бүлэгдээ Иеремиа Хинномын Хүүгийн хөндийд болсон аймшгийн зүйлийн тухай гуравдахь удаагаа өгүүлнэ. Гэтэл энэ удаад гайхмаар үгийг нэмж бичсэн. Иудейчүүдийг шийтгэснийхээ дараа Их Эзэн тэдэнд дахин энэрэл үзүүлж, тэднийг эргээд Иерусалимд цуглуулж, тэдэнтэй шинэ гэрээ байгуулна гэж бичсэн. Тухайлбал:

“Гэсэн хэдий ч ‘Илд, өлсгөлөн, тахлаас болж Вавилоны хааны гарт тушаагдаад байна’ гэж та нарын яриад байгаа энэ хотынхонд Израилын Бурхан ИАВЭ ийнхүү айлдаж байна:

Би уур, догшрол, их хилэнгээрээ цөлж явуулсан газар орон бүрээс нь тэднийг цуглуулан, энэ газарт авчирч, айх аюулгүй амьдруулах болно.

Тэд ард түмэн минь болж, Би Бурхан нь болно.

Тэдний насан туршид нь Надаас эмээж хүндлүүлэхийн тулд Би тэдэнд нэгдмэл бодол санаа, нэг зам мөрийг өгнө. Энэ нь тэдний, мөн хожмын үр хүүхдийнх нь сайн сайхны төлөө юм.

Тэдэнд сайн сайхныг үйлдэхээсээ Би огт буцахгүй гэсэн үүрдийн гэрээг тэдэнтэй байгуулна. Тэрчлэн тэдний оюун бодолд Надаас эмээхүйг өгснөөр тэд Надаас эргэж буцахгүй байх юм.





Би тэдний төлөө сайн сайхныг хийхдээ баярлана. Би бүхий л оюун бодол, бүхий л сэтгэл зүрхээ зориулан тэднийг энэ нутагт итгэл дүүрэн тарьж суулгана. ИАВЭ ийнхүү айлдаж байна. Энэ ард түмний дээр Би энэ бүх айхтар гай гамшгийг авчирсныхаа адилаар Өөрийн амласан бүхий л сайн сайхныг тэдэнд бас авчирна...” (Иеремиа 32:36-42, СМО)

Христийн үеийнхэн


Энэ бүхнийг Есүсийн үед амьдарч байсан иудейчүүд бүгд мэддэг байсанд эргэлзээ алга. Тэд “Гехенна” гэж сонсонгуутаа тэнд үйлдсэн аймшигт гэм нүгэл ба “Вавилоны цөллөг” гэдэг Их Эзэний авчирсан шийтгэлийн тухай бодсон нь лавтай. Тэгэхэд “Аллагын гуу” тухай зөгнөл үхэгсдэд биш, амьдаараа алуулах хүмүүст хамаатай болох нь тэдэнд тодорхой. Энэ шийтгэл хэзээ ч дуусахгүйгээр үргэлжлээгүйг тэд мөн мэдсэн. Хэзээ ч төгсөхгүй шийтгэлийн тухай ойлголт тэдэнд байгаагүй. Харин ч Их Эзэний хайр энэрэл эцэст нь бүх аймшгийг дийлж, ард түмнээ дахин сэргээхээр амалсан гэдгийг тэд мэдсэн.

Гехенна тухай ийм ойлголтыг Их Эзэн нэгэнт иудейчүүдэд өгсөн байхад тэр хөндийг хэрхэн үхэгсдэд хамаатуулж, тэдний мөнхийн мөнхөд шатсаар л байх шийтгэлийн газар болгон хувиргаж болох вэ?



Энэ бол Библийг Библиэр тайлбарлах ёстой гэсэн зарчмыг зөрчсөн хэрэг болох нь харагдсан. Энэ бол Хайрын Эзэнийг доромжилсон хэрэг болохыг ч мэдэгдсэн. □

Дараагийн нийтлэлдээ Гехеннагийн тухай хэлсэн Есүсийн үг чухам ямар учиртай болохыг авч үзнэ.





Ашигласан эх сурвалж

---Ариун Библи (2004; 2013; 2019). Улаанбаатар: Ариун Бичээс Нийгэмлэг. Энэ судалгаанд АБ гэж товчилсон.

---Библи (2015). Улаанбаатар : Монголын Библийн Нийгэмлэг. Энэ судалгаанд ББ гэж товчилсон.

---Bolen, Todd (2011). The Fires of Gehenna: Views of Scholars.

<https://www.bibleplaces.com/blog/2011/04/fires-of-gehenna-views-of-scholars/> [accessed October 22, 2023]

---Bolen, T. (2011). The Myth of the Burning Garbage Dump of Gehenna. <https://www.bibleplaces.com/blog/2011/04/myth-of-burning-garbage-dump-of-gehenna/> [accessed October 22, 2023]

---Germain, D. (2014). The Burning Garbage Dump of Gehenna- Myths That'll Preach.

<https://pulpitandpen.org/2014/06/05/the-burning-garbage-dump-of-gehenna-myths-thatll-preach/> [accessed October 22, 2023]

---Moore, G.F. (1897, Jan). Biblical notes (The Image of Moloch). Journal of Biblical Literature.

https://penelope.uchicago.edu/Thayer/E/Journals/JBL/16/Biblical_Notes/Image_of_Moloch*.html [accessed October 22, 2023]

---Стандарт Монгол Орчуулгын апп (2023). Энэ судалгаанд СМО гэж товчилсон.

---"Tophet of Carthage," in World History Commons,

<https://worldhistorycommons.org/tophet-carthage> [accessed October 22, 2023]

---Strong, J. (1890). Strong's exhaustive concordance of the Bible (with Greek and Hebrew Lexicons). www.blueletterbible.org